



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 9/150

Мандалговь

“Их дээд сургуулиудын өдөрлөг 2019”

арга хэмжээг зохион байгуулах

ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 а, Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн ерөнхий боловсролын төгсөх ангийн сурагчдад мэргэжлээ зөв сонгоход нь туслах зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Их дээд сургуулиудын өдөрлөг 2019” арга хэмжээг 2019 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр аймгийн төвд зохион байгуулсугай.

Хоёр. Арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Бумангэрэл (Боловсрол, соёл, урлагийн газрын дарга)

Гишүүд: Г.Хишигдаваа (Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга)
Ш.Наран-Эрдэнэ (Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)
Д.Доржсүрэн (Төв халхын дуулалт жүжгийн театрын дарга)
Ю.Цолмон (Мэргэжил, сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал)
Г.Цэрэнчимэд (Боловсрол, соёл, урлагийн газрын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Ц.Ганзориг (Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга)

Гурав. “Их дээд сургуулиудын өдөрлөг 2019” арга хэмжээг зохион байгуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган, зохион байгуулахыг ажлын хэсэг (Ц.Бумангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

488190412